

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

Шийдвэрийн дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц
1	3	4
Ерөнхийлөгчийн зарлиг		
1	2021.08.25 №39 “Ажлын хэсэг байгуулах тухай”	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 39 захирамжаар батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлт, түүний хор уршиг, нөлөөлөл болон цөлжилтийг бууруулах талаар санал дүгнэлт боловсруулах чиглэлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн.</p> <p>Хэрэгжүүлж байгаа ажлын талаарх танилцуулга</p> <ul style="list-style-type: none"> ✓ <input type="checkbox"/> 2022 онд Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт нь уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаа тухай тайлан мэдээ гаргах зорилгоор Монгол Улсын газрын нэгдмэл сангийн ангиллыг олон улсын IPCC/Уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын засгийн газар хоорондын хороо/-ээс гаргасан газар ашиглалтын газрын ангилалд хөрвүүлэн, газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн мэдээллийг үүсгэхээр систем хөгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж байна. ✓ <input type="checkbox"/> “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тус газраас улсын хэмжээнд мод тарих газар, мод үржүүлгийн талбайн байршлыг “Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-д бүртгэн газрын нэгдмэл сангийн ангиллаар доройтсон болон нөхөн сэргээх шаардлагатай газрын мэдээлэлтэй давхцуулж, төлөв байдлын өөрчлөлтөд мониторинг хийх, тухайн газрын мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаар судалгааны ажлыг хийж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор 2021, 2022 онд 1300 модыг тус газрын нийт албан хаагчид Хан-Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт тарьсан.
Засгийн газрын тогтоол		
1	2022 оны №182 Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай	Атар газраас тариалангийн газарт шилжүүлсэн газарт тухайн эрх бүхий этгээдийн шийдвэр гарч иргэн, хуулийн этгээдэд олгогдсоны дагуу газрын кадастын мэдээллийн санд бүртгэх чиглэлийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.
2	2022 оны №180 Хаягийн нэгдсэн сангийн нэгдсэн системийг орон зайн өгөгдөл, мэдээллийн геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар журмыг шинэчлэх, Хаягийн мэдээллийн системийг ажиллуулах журмыг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран байгуулсан ажлын хэсгийн хүрээнд 05 дугаар сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулж Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн. Тус мэдээлэлд суурилан зэрэгцүүлсэн хаягийн сан байгуулсан. Мөн тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар болон Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран 9 дүүргийн төрийн байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдэд хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ, ач холбогдолын талаар сургалт зохион байгуулсан.

3	2022 оны №171 Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай	Тус тогтоолоор Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар олгогдсон нийт 1217.4 га газрыг Газрын кадастрын мэдээллийн сангийн Улсын тусгай хэрэгцээний давхаргад 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр бүртгэсэн. “Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах” гурвалсан гэрээний төслийг бэлтгэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-г хүргүүлсэн.
4	2022 оны №7 Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг Монгол хэлээр сурталчлах ажлыг тогтмол хийж гүйцэтгэв. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны хагас жилийн хугацаанд 275 мэдээ, мэдээлэл бэтгэж, цахим хуудсанд оруулахдаа Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.
5	2021 оны 388 дугаар тогтоол Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд Төсвийн хэмнэлтийн горимд ажиллах чиглэлийг баримтлан ажиллаж өр, авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна. Тогтоолыг чанд мөрдөн, тогтоосон төсөвт зардлуудыг үргүй зарцуулахгүй байх, хэмнэх чиглэл барин ажиллаж байна.
6	2021 оны №374 Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолд заасан хугацаанд холбогдох байгууллагууд руу биелэлт, тайланг хүргүүлэн ажиллаж байна.
7	2021.10.13 №315 “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай”	Засгийн газрын 2021 оны 315 дугаар тогтоолын дагуу ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/215 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган ажилласан. Нийт 372 аж ахуйн нэгжийг 100 хувь аж ахуйн нэгжийн тооллогод хамруулсан.
8	2021.09.08 №280 Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай	“Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээн мэдээллийг Газрын кадастрын цахим системд бүртгэв. Мөн 3 талт гэрээний төслийг бэлтгэн Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Тус асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцан зохион байгуулахаар болсон тул 3 тал гэрээний төслийг хүргүүлэн санал авах ажиллагааг зохион байгуулж байна.
9	2021.06.01 №160 “Журам батлах тухай”	Тус журмын дагуу 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж төсвийн хязгаарт саналыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Мөн 2023 оны Төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулан Барилга, хот байгуулалтын яам болон Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж, уг журмыг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнахад үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.
10	2021.04.28 №109 “Журам батлах тухай”	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зорилгоор 2022 оны эхний хагас жилийн байдлаар 6 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан нийт 92 гаруй ярилцлага, фото сурвалжлага, нийтлэл, мэдээний сурвалжлага, шууд дамжуулалт хэлбэрээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 7 хоног бүр тогтмол мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд зориулж байгууллагын олон нийтийн сүлжээ /нуур ном/-нд иргэдэд хүргэн албан ёсны пейж хуудсанд 269 мэдээ, вэб хуудаст 61 мэдээ оруулав.

		2022 оны 2 дугаар улирлын байдлаар урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 9 тушаал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 38, зардал гаргасан 36 тушаалыг шилэн дансанд байршуулсан.
11	2021.05.05 №115 “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”	Газрын албан хаагчдыг PCR болон түргэвчилсэн шинжилгээнд тус бүр 2 удаа хамруулсан. Вакцины 1 дүгээр тунд 91 албан хаагчийг хамруулж, Вакцины 2 дугаар тунд 89 албан хаагчийг хамрагдаж, 3 дугаар тунд 16 албан хаагч хамрагдаад байна. 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нийт албан хаагчдын 10%, 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 30%-ийн ирцтэйгээр ажиллаж, үлдсэн 70% ийн ажилчид цахимаар ажилласан бөгөөд БХБЯмны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8 дугаар сарын 31-ны хооронд албан хаагчдын 70 хүртэлх хувьд ээлжийн амралт олгож биеэр эдлүүлсэн. Байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг уриалж ажилласан бөгөөд 10-11-р сард 56 албан хаагч хамрагдаад байна. Ковид-19 цар тахалын байгууллагын цаг үеийн мэдээг 2021 онд БХБЯ-ны шуурхай штабт өдөр бүр мэдээллэн ажилласан. 2022 онд 1 сард Коронавируст халдвар /Ковид/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. 2022 оны 02 дугаар сарын 14 өдрөөс эхлэн Засгийн газраас цар тахлын улбар шар түвшинг шар түвшинд шилжүүлж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг цуцалсан.
12	2021.03.24 №76 “Ажлын хэсэг байгуулах тухай”	Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн, Баян сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх Рашаант-Мааньт чиглэлийн Богдхан төмөр замын зурвас газарт иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад олгосон нийт 798,8 га талбай бүхий 749 нэгж талбарын нөлөөлөлд өртөж байгаа бөгөөд 71 тэр бум төгрөгний нөхөн олговор олгох урьдчилсан тооцоо, судалгааг гаргаж ажлын хэсэгт танилцуулсан.
13	2021.03.10 №58 “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай”	Тогтоолыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн ажиллав. Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлд хүргүүлэн Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж байна.
14	2021.02.21 №45 “Журам батлах тухай”	Түр журамд заасны дагуу халдварын судалгаа, өвчний мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, тандалтын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн халдварын тархалтын түвшинг тодорхойлж, Барилга, хот байгуулалтын яаманд тухай бүр хүргүүлэн ажилласан.
15	2021.02.17 №42 “Төлөвлөгөө батлах тухай”	Төлөвлөгөөний 1.3-т заасан “Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлэх” ажлын хүрээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем”-ийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 330 сумын Газрын даамал, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Газрын удирдлагын системийг E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна.
16	2020.09.02 №92 “Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын чигийг батлах тухай”	Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Төмөр замын шугамын чиг тогтоосон. Тогтоолд заасны дагуу батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх зорилгоор Газрын кадастрын мэдээллийн санд төмөр замын чиг шугамыг бүртгэж, шинээр газар олгох асуудлыг тухайн зурвас газарт зогсоосон байгаа болно. 2022.04.14-ний өдөр БХБЯ, ГЗБГЗЗГ-тай Богдхан төмөр замын төслийг эрчимжүүлэх

		<p>талаар уулзалт зохион байгуулж нарийвчилсан ажлын зураг, газар чөлөөлөлт, тусгай хэрэгцээнд авах ажлыг удирдан зохион байгуулах дэд ажлын хэсгийн тушаалын төсөл боловсруулах чиглэл өгсөний дагуу тушаалын төслийг боловсруулан Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалын төслийг боловсруулан 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Барилга, хот байгуулалтын яамны Бодлого төлөвлөлтийн газарт цахимаар хүргүүлсэн.</p>
17	<p>2020.04.29 №152</p> <p>“Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оын 04 дүгээр сарын 02 өдрийн 152-р тогтоолоор батлагдсан журмын өөрчлөлтийн хүрээнд газрын дуудлага худалдааг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Улсын хэмжээнд газрын цахим биржийн системээр дамжуулан нийт 3505 газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулаад байна.</p> <p>Газрын биржийн цахим системээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан тоогоор газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулдаг бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар нийт 2073 газрын газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан. Нийт зохион байгуулсан дуудлага худалдаанаас 2005 нь цахим хэлбэрээр, 68 нь танхимаар зохион байгуулагдсан. Мөн 392 дуудлага худалдааг дахин зохион байгуулсан. Дуудлага худалдаанд нийт 3805 иргэн, хуулийн этгээд оролцож, ойролцоогоор 3.7 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.</p>
18	<p>2020.03.25 №110</p> <p>“Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай”</p>	<p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем”-ийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 330 сумын Газрын даамал, нийслэл болон дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Мөн Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээд газрын эрхийн баримт бичиг болох газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, нэгж талбарын кадастрын зургийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем /egazar.gov.mn/-д танилт нэвтрэлтийн “Дан” системээр нэвтэрч, системээс нууцлал бүхий QR кодоор баталгаажуулж, цахим хэлбэрээр авах, нэгж талбарын дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлолт хэлбэрээр цахимаар авах, Монгол улсын иргэнд үнэгүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа мэдээллийг цахимаар авах, мөн 16 төрлийн газар холбоотой хүсэлтийг цахимаар тухайн шатны Газрын албанд цахимаар гаргах боломжийг бүрдүүлж, системийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.</p> <p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэн, аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Одоогийн байдлаар нийслэл, сум, дүүргийн 2019-2021 газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг системд бүрэн оруулж, кадастр, цахим биржийн системээр дамжуулан төлөвлөлтийн дагуу газар олгох ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 9 сарын байдлаар системд 1700 газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичиг цахим хэлбэрээр байршиж, хэрэгжиж байна.</p> <p>Газар зүйн нэр төрлийн 18 стандартын төслийг 2021 оны 05 дугаар сарын 11-нд зохион байгуулагдсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцүүлж, хурлаас үүрэг болгосон хугацаанд батлуулах шийдвэр гарсан. Дээрх стандартын төслүүдийг батлуулах үүрэг бүхий Стандарт хэмжил зүйн газартай хамтарсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/110 тоот тушаалаар батлуулж, ажлын хэсгийн байгуулж стандартын төсөлд санал авсан. Энэхүү стандартад санал авахаар Стандарт хэмжил зүйн газраас 71 байгууллага руу 1/307, ГЗБГЗЗГ-аас нийт 49 байгууллагууд руу 1/1067 албан тоот бичиг тус</p>

		<p>тус хүргүүлж, нийт албан бичиг илгээсэн 120 байгууллагаас 47 байгууллага саналгүй, дэмжиж байгаа болохоо илэрхийлсэн (утсаар болон цахим шуудангаар). Нийт 26 байгууллагаас санал ирсний дагуу саналын товчоог хамаарах стандарт тус бүр дээр гаргасан. Ирүүлсэн саналын дагуу холбогдох санал, зөвлөмж, найруулга зэргийг тусгасан. Дээрх асуудлын хүрээнд ГЗБГЗЗГ-ын даргын А/110 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дундаа цахим хэлбэрээр /googledoc/ файл нээж, түүгээр дамжуулан шүүлт хийн стандарт боловсруулагч талтай зөвшилцөн стандартын төслийг эцэслэн боловсруулсан. 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Техникийн Хороогоор хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тоот тушаалаар батлуулсан.</p>
Ерөнхий Сайдын захирамж		
1	<p>2022 оны 01 дүгээр Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай</p>	<p>2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Газрын шуурхай хуралд Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц барих газар орчмын нөлөөлөлд өртөж байгаа газрын судалгааг гаргаж Газрын удирдлагад танилцуулсан.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр БХБЯ, Баян-Өлгий, Увс аймгийн ГХБХБГ, УЦС-ын төсөл хэрэгжүүлэгч нартай цахим уулзалт хийж, багийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрхэн боловсруулах, байршлыг хэрхэн сонгох, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар уулзалт хийсэн.</p> <p>Увс аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/06 тоот тогтоолоор Өмнөговь сумын Улиаст багийн төвийг Рашаантын хотгорт 48 га газарт байршил шилжүүлэх асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотголоор оруулж баталсан.</p> <p>Зорилт 2.1.7. Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх</p> <p>Хэрэгжилт: Монгол улсын засгийн газрын “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор батлагдсан.</p> <p>Монгол улсын их хурлын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Хөшгийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай”, газрын хэмжээг 1000 га газар эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар тус тус тогтоосон.</p> <p>Улаанбаатар хотын унд ахуйн усны баруун шинэ эх үүсвэрээс Хөшигийн хөндий дэх хот суурин газрыг унд, ахуйн усаар хангах гол шугамын зурвас /чиглэл/ тогтоох техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэх ажил хийгдэж байна.</p> <p>Зорилт 4.3.1. Хангайн бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилт: Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулан холбогдох газруудтай зөвшилцөн, санал авч тусган Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Төслийн дагуу 2021/68 дугаар зургийн даалгавар 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Барилга хот байгуулалтын сайд баталсан.</p> <p>2022 онд зургийн даалгаварт нэмэлт тодотгол хийж Барилга хот байгуулалтын яамны ХБГХБХЗГ-т хүргүүлсэн.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд Барилга хот байгуулалтын яамнаас 202212123 дугаар зөвлөх үйлчилгээний тендер зарласан боловч материалын шаардлага хангаагүй шалтгаанаар гүйцэтгэгч шалгараагүй байна.</p>

		<p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Эн Эй Пи” ХХК-нд боловсруулсан Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг судлан танилцаж тус яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогыг хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэн АИТХ-ын тогтоолоор батлагдсан.</p>
2	<p>2021.06.24 №112</p> <p>“Ажлын хэсэг байгуулах тухай”</p> <p>Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын хүчин чадал бүхий “Усан цахилгаан станц барих төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Газрын шуурхай хуралд Эрдэнэбүрэнгийн УЦС барих газар орчмын нөлөөлөлд өртөж байгаа газрын судалгааг гаргаж Газрын удирдлагад танилцуулсан. 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр БХБЯ, Баян-Өлгий, Увс аймгийн ГХБХБГ, УЦС-ын төсөл хэрэгжүүлэгч нартай цахим уулзалт хийж, багийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрхэн боловсруулах, байршлыг хэрхэн сонгох, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар уулзалт хийсэн.</p> <p>Увс аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/06 тоот тогтоолоор Өмнөговь сумын Улиаст багийн төвийг Рашаантын хотгорт 48 га газарт байршил шилжүүлэх асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотголоор оруулж баталсан.</p> <p>Тус газрын 2021 оны 05 сарын 12-ны 1/919 тоот албан бичгээр ажлын хэсэгт орж ажиллах албан тушаалтны нэрийг хүргүүлсэн. Тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ олгож, ажлын хэсгийн хуралд оролцож, зөвлөмж, саналыг тусгуулан ажиллаж байна.</p>
3	<p>2021.06.28-ны өдрийн №113</p> <p>“Гашуун сухайт-Ганцмод” төмөр замын боомтын хилийн нэвтрэх хэсгийг Хятадын талтай тохиролцоо ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулах тухай</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлцээр"-ийн дагуу шинээр байгуулах Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын хилийн төмөр замын хил нэвтрэх цэгийг хятадын талтай тохиролцоо ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт газрын харилцаатай холбоотой мэдээллээр хангаж ажиллах болно.</p>
4	<p>2021.03.31 №85</p> <p>Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2022 оны 02 сард санал өгөв. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2022.04.04ний өдрийн 48 дугаар захирамжаар Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталж, Сансрын үндэсний зөвлөлийн дарга Сансрын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ЦЕГ, МУ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран сансрын зураг орон зайн мэдээлэл боловсруулах сургалт явуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		
1	<p>2022 оны 124/14</p> <p>Газрын мониторингийн үр дүнгээр улсын хэмжээнд бэлчээрийн даац хэтэрсэн газрын төлөв байдал, ашиглалтад орон зайн дүн шинжилгээ хийж, шинээр хөв цөөрөм, худаг гаргах асуудлыг судалж, шийдвэрлэх</p>	<p>2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ХХААХҮЯ, Усны газартай хамтарсан уулзалт хийж, ХХААХҮЯ, Усны газар, ГЗБГЗЗГ хамтарсан ажлын хэсэг гаргаж уг асуудлыг судлах, дүн шинжилгээ, зураглал хийх чиглэлээр ажиллахаар боллоо.</p>

2	<p>2022 оны 124/14</p> <p>Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай</p>	<p>Энэ ажлын хүрээнд БОАЖЯ-ны төлөөлөл, ГЗБХ-ийн дарга Ж.Батсайхан, Смарт эко транс ХХК-тай уулзалт хийсэн. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах газрын байршлыг тогтоох ажлыг 2022 оны 3 дугаар сарын 25-26-ны өдөр хийсэн.</p> <p>Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг тогтоосон мэдээллийг ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/594 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлсэн.</p>
3	<p>2021.10.27</p> <p>“Агентлагын дарга нарт”</p>	<p>Газрын албан хаагчдыг PCR болон түргэвчилсэн шинжилгээнд тус бүр 2 удаа хамруулсан. Вакцины 1 дүгээр тунд 91 албан хаагчийг хамруулж, Вакцины 2 дугаар тунд 89 албан хаагчийг хамрагдаж, 3 дугаар тунд 16 албан хаагч хамрагдаад байна. 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нийт албан хаагчдын 10%, 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 30%-ийн ирцтэйгээр ажиллаж, үлдсэн 70% ийн ажилчид цахимаар ажилласан бөгөөд БХБЯмны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8 дугаар сарын 31-ны хооронд албан хаагчдын 70 хүртэлх хувьд ээлжийн амралт олгож биеэр эдлүүлсэн. Байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг уриалж ажилласан бөгөөд 10-11-р сард 56 албан хаагч хамрагдаад байна. Ковид-19 цар тахалын байгууллагын цаг үеийн мэдээг 2021 онд БХБЯ-ны шуурхай штабт өдөр бүр мэдээллэн ажилласан. 2022 онд 1 сард Коронавируст халдвар /Ковид/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. 2022 оны 02 дугаар сарын 14 өдрөөс эхлэн Засгийн газраас цар тахлын улбар шар түвшинг шар түвшинд шилжүүлж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг цуцалсан.</p>
4	<p>2021.07.08</p> <p>Засгийн газрын Агентлагын дарга нарт</p> <p>/УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан, салбарын хэмжээнд хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлэн, ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан " Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд гаргах/</p>	<p>Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна.</p>
5	<p>2021.07.08</p> <p>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт</p>	<p>Засгийн газрын 2021 оны 38-р хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 160 дугаар тушаал, Төв аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/422 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, бэлтгэл ажлыг хангасан.</p>

	<p>/Төв аймгийн Хөшигийн хөндийн дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлт /Концепци/-ийн дагуу бүсийн хөгжлийн төслийг боловсруулж, төлөвлөгөө гаргаж, арга хэмжээг авч хэрэгжүүлэх/</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй 19390.4 га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа нийт 2983 нэгж талбарын 7603.7 га газар давхцалыг тодорхойлсон.</p> <p>Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 202/196 дугаар хамтарсан тушаалаар баталсан аргачлал, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалыг баримтлан давхцалтай 2983 нэгж талбараас газар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа болон үл хөдлөх хөрөнгөтэй 183 нэгж талбарт мэргэжлийн байгууллагаар урьдчилсан үнэлгээ хийлгэхэд 40.532.510.036 төгрөгийн нөхөх олговорын тооцоо гарсан.</p> <p>Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай хамтран зөрчилтэй болон хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох ажиллагааг Захиргааны ерөнхий хууль болон Газрын тухай хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
6	<p>2021.06.21</p> <p>Агентлагын дарга нарт</p> <p>/Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, төвийн цахим програм хангамжийг бүрэн ашиглах, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг мэдээлэх,</p>	<p>Тус газарт эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс нийт 35 өргөдөл, хүсэлт ирснийг судлан 31 хүсэлтийг хугацаанд нь хариу хүргүүлж шийдвэрлэсэн. Судалж байгаа 4 өргөдөл, хүсэлтийг судлан, хугацаанд нь хариу хүргэн шийдвэрлэхээр ажиллаж байна.</p>
7	<p>2021.06.01</p> <p>Салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	<p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны баримт бичгийн 2021 оны хэрэгжилтийн явцын тайланг гарган Барилга, хот байгуулалтын яаманд цахим шуудангаар, Үндэсний хөгжлийн газарт 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 3/1771 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг болон “Бүсийн хөгжлийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгийн боловсруулж буй “Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т тусгах саналаа 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 2/1690 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг ханган тухай бүрд нь тайлагнан ажиллаж байна.</p>
8	<p>2021.04.14 №24</p> <p>Монгол улсын Газрын нэгдмэл сангийн 2020 оны тайлангийн талаар</p>	<p>Тус хурлын тэмдэглэлд тусгагдсаны дагуу “Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-тай холбох, сервис үйлчилгээ гаргах ажлыг гүйцэтгэх” АД/2021-26 дугаар бүхий ажлын даалгаварыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр ГЗБГЗЗГ-ын дарга баталсан. Тус ажлын даалгаварт тусгагдсан 14 төрлийн сервис үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/-тай холбох ажлыг 2021 оны</p> <p>09 дүгээр сарын 06-ны өдрөөс тус оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хооронд гүйцэтгүүлэхээр “Софт мастер” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.</p> <p>Газрын төлбөр, татвар, Улсын тэмдэгтийн хураамжийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/, төлбөрийн цахим систем Ebarimt-аар төлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн Үйлчилгээний хураамжийг Ebarimt цахим төлбөрийн</p>

		<p>системээр төлөх хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь уг үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх зөвшөөрөл хүлээгдэж байна.</p> <p>Газрын нэгдмэл сангийн 2020 оны “Газарт учирсан хохирол”-ын ГТ6 тайлан, “Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний ГТ7 тайланг 21 аймаг, нийслэлээс хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2020 онд улсын хэмжээнд нийт 5'559'192.9 га газарт хохирол учирсан байгаа бөгөөд өмнөх оны дүнгээс 2'256'521.2 га талбайгаар бага байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 86'622.2 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 5'255'560.7 га, хот тосгон, бусад суурин газрын 44'178.0 га, ойн сан бүхий газрын 136'588.9 га, усны сан бүхий газрын 151.0 га газарт тус тус хохирол учирсан бол 36'092.0 га газар ухагдаж эвдэрсэн байна. 2020 онд улсын хэмжээнд нийт 4'089'216.7 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан бөгөөд өмнө оны дүнгээс 843'890.5 га талбайгаар их байна. Үүнийг дотор нь ангилан үзвэл тариалангийн 228'981.7 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 3'785'850.7 га, хот тосгон, бусад суурин газрын 29'595.0 га, ойн сан бүхий газрын 28'012.6 га, усны сан бүхий газрын 426.7 га газарт хамгаалах арга хэмжээг авсан бол 16'349.0 га газрыг уурхайн эдэлбэр газарт нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна.
9	2021.09.29 №53 “Агентлагын дарга нарт”	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу холбогдох тайлан мэдээг хугацаанд нь гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. Мөн 21 аймаг, нийслэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тогтоолын дагуу үнэлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.
10	2021.09.15 №51 БОАЖЯ, Газрын газрын харилцааны салбарын мэдээллийн сан, улсын тусгай хэрэгцээнд авсан газрын мэдээллийг "Орон зайн мэдээллийн сан"-д оруулах, олон нийтэд нээлттэй болгох	Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах арга хэмжээний төлөвлөөнд туссан Үндэсний орон зайн өгөгдлийн геопорталыг хөгжүүлж, үйл ажиллагаанд оруулах ажлын хүрээнд орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, ашиглагч, түгээгч байгууллагуудын мэдээллийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тушаалаар батлуулсан суурь орон зайн 18 дэд сан бүрт зориулан өгөгдлийн үзүүлэлтийн /UML/ стандартын дагуу хөрвүүлэн дээрх геопорталд оруулах ажлын хийж гүйцэтгээд байна. Үүнд, БОАЖЯ-ны мэдээллүүд болох тусгай хамгаалалтад авсан газрын мэдээлэл “Газар ашиглалт” төрөлд хамаарч нэгдсэн мэдээллийн санд орсон болно. Ингэснээр тус байгууллагын мэдээллийн сан нь газрын харилцааны мэдээллийн сантай нэгтгэгдэн геопорталаар дамжин иргэд олон нийтэд нээлттэй болсон.
11	2021.03.31 №21 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар	Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолд заасны дагуу холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна.
Барилга, хот байгуулалтын Сайдын тушаал		
1	2022 оны №85 Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай	Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны “Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай” 85 дугаар тушаалыг 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан харьяа газруудад чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2	2021 оны №253 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Геодези, зураг зүйн	<p>Журамд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>2022 оны 2-р улиралд цахим ситемээр дамжуулан геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахаар давхардсан тоогоор 43 хүсэлт ирсэн. Үүнээс:</p>

	үйлдвэрлэл, үйлчилгээ, эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"	Шийдвэрлэгдсэн 21 Ажлын хэсэгт шилжсэн 2 Суурь нөхцөл шаардлага хангаагүй тул буцаагдсан 14 Хянагдаж байгаа 2 Татгалзсан шийдвэр гарсан 6 хүсэлт байна.
3	2021.07.19 №160 Ажлын хэсэг байгуулах тухай	Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 270 дугаар тушаалаар байгуулсан Улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай байгаа нэгж талбарын газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 3 удаа, Төв аймгийн Засаг даргын 2022 оны А/54 дүгээр захирамжаар байгуулсан дэд ажлын хэсэгтэй хамтарсан хурлыг Зуунмод хотод 1 удаа зохион байгуулсан. Тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралд тухай бүр хэрэгжилтийн тайланг хүргүүлэн ажиллаж байна.
4	2021.03.03 №44 Журмын хэрэгжилтийг хангах тухай	21 аймаг, нийслэлд дуудлага худалдааны орлогын тусгай дансыг нээж газрын дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлж байгаа бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар ойролцоогоор 3.7 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна. Мөн Газрын биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын уялдаа, хяналтын тогтолцоог хангуулах үүрэг бүхий Газрын биржийн Удирдах зөвлөлийн хурлыг 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хуралдсан бөгөөд тус хуралдаанаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад газрын биржийн данс нээх асуудлыг шийдвэрлүүлэх, БХБ-ын сайдын 2021 оны 44 дүгээр тушаалын дагуу дуудлага худалдааны орлого зарцуулалтын ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэн төсвийн төсөөлөлд санал хүргүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын яаманд багцын гүйлгээ хийх дансыг нээх асуудлыг шийдвэрлэж зарцуулах эрхийг тус газарт олгох, иргэн, хуулийн этгээдэд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын хураамж, дэнчинг багцын гүйлгээгээр хийх, АСН+ (автомат клиринг хаус систем)-ийг үйл ажиллагаандаа ашиглах хүсэлтийг 1/928 тоот албан бичгээр гаргаад байна.
5	2019.03.26 №53 Журам батлах тухай	Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 245 дугаар тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох, хяналт тавих журам"-ын 3.1.Эрх авах, сунгуулах, дахин олгуулах, мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ зохион байгуулагч байгууллагад Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим систем /цаашид "цахим систем" гэх/ "license.mcis.gov.mn"-ээр дамжуулан 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 5 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх байдлаар нийт 8 хүсэлтийг хүлээн авч суурь шаардлага хангасан 7 аж ахуйн нэгж байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг олгоод байна.
6	2019.03.26 №54 Журам батлах тухай	Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар баталсан уг журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгээгүйн улмаас Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар баталж, тухайн тушаалын хэрэгжилтэнд хяналт тавих байгууллагаар Барилгын хөгжлийн төвийг томилон ажиллаж байгаа болно. Харин журмын төслийг шинээр боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/2404 дугаар албан тоотор хүргүүлсэн.